



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 25 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

“Барилгын хөгжлийн төв”
төрийн өмчит үйлдвэрийн газрын
2018 оны төлөвлөгөөнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 650 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний “...хөрөнгө оруулалт 222,220.0 мянган төгрөг” гэснийг “...хөрөнгө оруулалт 315,702.0 мянган төгрөг” гэж өөрчилсүгэй.

2. “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 650 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

3. Төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал Ц.Амарсанаад даалгасугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



0002235

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн
107 дугаар тогтоолын хавсралт

**“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2018 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВДӨГӨӨНД
НЭМЭГДЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Төсөвт өртөг
12	Ханын шкаф	2	1,350,000.0	2,700,000.0
13	Суудлын автомашин	1	68,707,800.0	68,707,800.0
14	Хурлын өрөөний ширээ	1	5,800,000.0	5,800,000.0
15	Хурлын өрөөний сандал	22	250,000.0	5,500,000.0
16	Сургалтын өрөөний тоног төхөөрөмж	1	3,599,200.0	3,599,200.0
17	Барилгын лабораторийн тоног төхөөрөмж	2	3,587,500.0	7,175,000.0
	НИЙТ ДҮН			93,482,000.0